



Талуудын оролцоог хангах уулзалтын ТӨЛӨВЛӨГӨӨ

Клин Энержи Ази ХХК

2016 оны 5-р сарын 12

Агуулга

Бүлэг	Гарчиг	Хуудас
1	Танилцуулга	1
1.1	Товч танилцуулга_____	1
1.2	Төслийн тодорхойлолт _____	1
1.2.1	Байгаль орчин ба нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг хийх үйл явц_____	2
2	Засаг захиргааны шаардлагууд	3
2.1	Монгол улсын хууль тогтоомж _____	3
2.2	ЕСБХБ-ний шаардлагууд _____	3
2.3	Орхусын Конвенци _____	4
3	Оролцогч талуудтай өмнө нь хийсэн уулзалтын үйл ажиллагааны дүгнэлт	5
4	Оролцогч талуудыг тогтоох ба харилцах аргууд	6
5	Хэлэлцүүлэх ба ил болгох хөтөлбөр	11
5.1	Нөөц боломж ба үүрэг хариуцлага_____	11
6	Гомдол барагдуулах механизм	14
7	Компанитай холбогдох мэдээлэл	16
	Хавсралт А: Олон нийтэд зориулсан санал гомдлын маягт	17

1 Танилцуулга

1.1 Товч танилцуулга

Клин Энержи Азия ХХК (КЭА) нь 50МВт-ийн хүчин чадалтай, 25ш салхин цахилгаан үүсгүүрүүдээс (СЦҮ) бүрдэх салхин паркийг (Төсөл) хөгжүүлэх төлөвлөгөөтэйгээр тусгайлан байгуулсан компани юм. КЭА-ийг Монгол Улсын Ньюком групп болон Япон Улсын Софтбанк Корпорацийн Сэргээгдэх эрчим хүч хариуцсан салбар компани болох СБ Энержи Корпорациуд үүсгэн байгуулсан юм. Уг Төслийг Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны (ЕСБХБ) шалгууруудад нийцүүлэн хөгжүүлэх болно. Харин энэхүү бичиг баримт нь КЭА-ийн Оролцогч Талуудтай Уулзах Төлөвлөгөө (ОТУТ) юм. Уг ОТУТ-ний зорилго нь төсөлтэй хамаатай оролцогч талуудтай үр дүнтэй, ач холболдолтой харилцаанд хүргэх КЭА-ийн үүрэг хариуцлага, арга барилыг тогтоож, тодорхойлоход оршино. Энэхүү ОТУТ хэрэгжилт нь дотоодын хууль журам, ЕСБХБ-аар тодорхойлогдсон олон улсын шилдэг туршлагаудыг дагаж мөрдөхөд КЭА-д тус дэм болно.

1.2 Төслийн тодорхойлолт

Салхин парк дараах бүрдэл хэсгүүдээс бүрдэнэ:

- 25ш СЦҮ-ууд (2МВт-ийн нэгж чадалтай)
- Суурин ажилчдын байр, талбай дээрх захиргааны байр зэргээс бүрдэх Удирдлагын төв
- Хатуу хучлагатай хурдны автозамаас Төслийн талбай хүртэлх нэвтрэх автозам.
- Цэций салхин цахилгаан станцын дэд станцаас Цогтцэций сумын баруун талд байрлах Төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон үндсэн дэд станц хүртэл 34км-ийн урттай 110кВ-ийн цахилгаан дамжуулах агаарын шугам.
- Удирдлагын төвөөс СЦҮ-ууд хүртэлх сайжруулсан автозамууд болон СЦҮ-үүдээс удирдлагын төв хүртэлх газар доорх цахилгааны кабелиуд.
- Барилгын ажиллагсадын байрлах түр бааз.

Төслийн талбай нь Нийслэл Улаанбаатар хотоос урд зүгт ойролцоогоор 542 км, Даланзадгадаас зүүн зүгт 98км, Цогтцэций сумын төвөөс урд зүгт 22км зайд, 72км² дэвсгэр талбайг хамран орших зэлүүд, удам задгай цөл нутаг юм (Зураг 1.1 харна уу). Талбай нь Монголын өмнөд бүст Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Сийрст багийн нутаг дэвсгэрт байрлана.


Төсөл нь төрийн өмчит компани болох “Эрдэнэс Таван Толгой”-ийн эзэмшдэг “Таван Толгой” болон “Энержи Ресурс” ХХК-ийн эзэмшдэг “Ухаа Худаг” гэх хоёр том нүүрсний ил уурхайн зүүн урд талд байрлана. Төслийн талбайн хамгийн ойрхон эргэлтийн цэг нь дээрх уурхайгаас 8км-ийн зайтай байна. Ойр хавьд нь бусад жижиг уурхайнууд байх ба тэдгээрийн зарим нь төслийн хойд ба баруун зах дээр байрлах бааз, засварын газруудтай. Хятад руу гаргаж буй нүүрсний экспортын сайжруулсан шороон замууд Төслийн талбайн яг хойгуур гарах бөгөөд уг зам нь хилийн боомт хүртэл 200 орчим км үргэлжлэнэ. Мөн нүүрсний экспортод зориулан шинэ төмөр замыг барьж байгаа бөгөөд баригдаж дуусах үед нүүрс тээвэрлэлтийн өөр нэг хувилбар болж өгнө.

Төслийн талбайн хойд болон баруун хэсэг нь харьцангуй хавтгай, өргөн удам тал хээрийн шинжийг агуулах ба цөөхөн бут сөөгтэй, тачир ургамалан бүрхэвчтэй. Харин урд ба зүүн хэсэг нь мөн сийрэг ургамалтай бөгөөд орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг болох Цэций уулын хормой ба дов толгодорхог газар юм.

Талбайд талбайд малчид малаа бэлчээждэг бөгөөд Цэцийн уулын орчимд байрлах өвөлжөө болон гар худгийг ашигладаг. Уг талбайд малын бэлчээрээс гадна олон тооны шороон замууд дайран гардаг оршдог.

Төслийн барилга угсралтын ажлыг 2016 оны 5-р сард эхлүүлж, 2017 оны 11-р сард ашиглалтанд оруулахаар төлөвлөж байна. Төслийн барилга угсралтын ажлыг явуулахдаа олон талт гэрээний бодлого барих бөгөөд ө.х. үүнд СЦҮ-ийн үйлдвэрлэгчтэй СЦҮ нийлүүлэх гэрээ, Станцын бусад ажлыг хийх (СБА) Гэрээлэгчтэй СЦҮ-ийн угсралт, барилгын болон цахилгааны ажлуудыг гүйцэтгүүлэх гэрээ зэрэг гол гэрээнүүд багтана.

Зураг 1.1: Төслийн байрлал



Эх сурвалж: Сгурр Энержи (2015)

1.2.1 Байгаль орчин ба нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг хийх үйл явц

Дотоодын хууль журмын дагуу хийсэн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2014 онд хийж дуусгасан. тус БОННУ-г Монгол Улсын Байгаль орчин, Ногоон Хөгжил, Аялал Жуулчлалын яамнаас баталсан болно. ЕСБХБ-наас Зэрэглэл “В”¹-ээр ангилагдсан уг төсөлд зориулсан олон улсын стандартад нийцүүлсэн Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг Сгурр Энержи хийж байна. Уг БОННБҮ-ээр Төслийн нөлөөлөл болон үр өгөөжийг үнэлж, эдгээр нөлөөлөл болон үр өгөөжүүдийг хянан удирдах арга хэмжээг тогтоох болно.

¹ Төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүд нь үндсэндээ талбай- төвтэй эсвэл/ба бууруулах арга хэмжээгээр дамжуулан хялбархан тогтоогдож, шийдэгддэг Төслүүд.

2 Засаг захиргааны шаардлагууд

Төслийн оролцогч талуудын өмнө хүлээсэн КЭА-ийн үүрэг амлалт болон компанийн сайн засаглалын нэг хэсэг болох энэхүү ОТУТ-ийг олон улсын шилдэг туршлага, ялангуяа ЕСБХБ-ний Гүйцэтгэлийн Шаардлагууд (ГШ) болон Монгол улсын хуулиудад нийцүүлэн боловсруулав. Мэдээллийн хүртээмж, шийдвэр гаргахад олон нийтийн оролцоо, байгаль орчны эрх тэгш, шударга ёсны хүртээмж зэрэгтэй холбоотой Нэгдсэн Үндэсний Байгууллагын Европын Эдийн Засгийн Хорооны (НҮБЕЭЗХ) Орхус Конвенци (2001)-д тусгасан олон улсын сайн туршлагаудтай Монгол орны хуулиуд мөн нийцдэг.

2.1 Монгол улсын хууль тогтоомж

Төслийн хэрэгжүүлэлт, байгаль орчин хамгаалах арга хэмжээний оролцооны талаар мэдээлэл авах иргэдийн эрхтэй холбогдох Монгол улсын хуулиудад дараах хуулиуд багтана:

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль (БОНБНУ хууль) (2012),
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль (БХУЗ хууль) (2003 онд батласан, 2006 онд нэмэлт өөрчлөлт оруулсан).

БОНБНУ хуулиар БОНБНУ-ний үйл явцад олон нийтийн оролцоо шаардлагатай гэж заасан байдаг. Тус хуулийн 5.4-р Зүйлд БОНБНУ-ийг явуулах, бэлдэх явцад тухайн орон нутгийн иргэдийн үзэл бодлыг оруулж, шийдвэрлэхийг шаарддаг. Гэсэн хэдий ч уг хуулинд нутгийн иргэдийн үзэл бодлыг зураг төсөл болон ашиглалтын үе шатны хувьд хэрхэн тусгахыг заасан онцлог шаардлагууд байдаггүй.

БХУЗ хуулиар үндсэндээ бүс нутгийн хөгжлийг зохицуулах, нийгэм эдийн засгийн зорилгуудыг тэнцвэржүүлэхийг зоридог. Бүс нутгийн хөгжлийн үйл явцад нутгийн өөрөө удирдах байгууллагуудын эрх мэдлийг энэ хуулинд оруулсан байдаг. Уг хуулийн дагуу нутгийн өөрөө удирдах байгууллагууд бүс нутгийн хөгжлийн үйл явцад иргэдийг оролцуулах, зохих санал, хүсэлт гомдолд хариулах, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын шууд оролцоог дэмжих үүрэгтэй юм.

2.2 ЕСБХБ-ний шаардлагууд

ЕСБХБ зэрэг Олон Улсын Санхүүгийн Институтаар санхүүжүүлэгдэх бүхий л төслүүдээс олон шилдэг туршлагыг хангасан байхыг шаарддаг ба ялангуяа ЕСБХБ-ний Гүйцэтгэлийн Шалгуур 1: Байгаль орчин ба нийгмийн судалгаа, менежмент болон ГШ 10: Мэдээллийг нийтлэж, ил болгох ба Оролцогч талуудын оролцоог хангах уулзалтын төлөвлөгөөнд тусгасан оролцогч талуудын уулзалт, олон нийтийн хэлэлцүүлэгт зориулсан шаардлагуудыг хангахыг шаардана.

Ерөнхийдөө ЕСБХБ нь төсөлтэй холбоотой мэдээллийг нийтлэх, ил болгох болон байгаль орчин, нийгмийн үнэлгээний явцын хамгийн эхний шатуудад орон нутгийн иргэд болон бусад оролцогч талуудтай тэдэнд шууд нөлөөлөх эсвэл сонирхлыг нь татах зүйлсийн талаар хэлэлцүүлэг хийж, түүнийг Төслийн бүхий л шатанд үргэлжлүүлэн үр дүнтэй байдлаар олон нийтэд чиглэсэн арга хэмжээ явуулахыг шаарддаг.

ЕСБХБ-ний шаардлагын хувьд мэдээллийг нийтлэх, ил болгох гэдэг нь дараахтай холбоотой мэдээллийг авах боломжоор оролцогч талуудыг хангах гэсэн утгатай:

- Төслийн зорилго, мөн чанар ба хэмжээ
- Санал болгож буй төслийн үйл ажиллагааны үргэлжлэх хугацаа
- Нутгийн хүмүүс зэрэгт үзүүлэх аливаа болзошгүй нөлөөлөл эсвэл эрсдэл болон холбогдох бууруулах арга хэмжээ
- Төлөвлөж буй оролцогч талуудтай уулзах үйл явц,
- Хүмүүсийн санал хүсэлт эсвэл гомдол гаргаж болох журам эсвэл бодлого (гомдол барагдуулах механизм)

Төслөөс тогтоосон эрсдэл ба сөрөг нөлөөллүүдэд нутгийн хүмүүс өртөхөөр үед нөлөөлөлд өртөх хүмүүст төслийн эрсдэл, нөлөөлөл, бууруулах арга хэмжээний талаар өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх, үйлчлүүлэгчид тэдгээрийн харгалзан үзэх, хариулах боломжийг олгосон хэлбэрээр хэлэлцүүлгийг явуулахыг үйлчлүүлэгчээс шаарддаг. Үр дүнтэй хэлэлцүүлэгт дараах зүйлсийг авч хэрэгжүүлэх хэрэгтэй:

- Байгаль орчин ба нийгмийн эрсдлүүд, нөлөөллүүдийг тодорхойлох үйл явцын эрт шатанд эхэлж, эрсдэл ба нөлөөлөл учрах явцад тогтмол үргэлжлүүлэх
- Нөлөөлөлд өртсөн нутгийн хүмүүст ойлгогдох, соёлын хувьд тохиромжтой хэл, хэлбэрээр холбогдолтой, ил тод, зорилготой, утга учиртай, хялбархан олж авч олох мэдээллийн нийтлэл, түгээлтэд үндэслэх
- Шууд бусаар нөлөөлөгдсөнөөс илүүтэйгээр шууд нөлөөлөлд өртсөн хүмүүсийг хамруулсан харилцаанд төвлөрөх.
- Гадны нөлөө, оролцоо, дарамт шахалт эсвэл айлган сүрдүүлэлтээс хамааралгүй байх
- Боломжтой бол ажил хэрэгч оролцоог бий болгох,
- Албажуулж, баримтжуулж байх.

2.3 Орхусын Конвенци

1998 онд Мэдээллийн хүртээмж, шийдвэр гаргахад олон нийтийн оролцоог хангах болон байгаль орчинтой холбоотой хэрэгт хууль ёсны шударга үйлчлэлийг хангах тухай конвенци (Орхусын Конвенци)-ийг НҮБЕЭЗХ-оос баталсан. 2011 оны 7-р сарын 5-нд уг Конвенцид Нэгдсэн Талуудын Уулзалтаар НҮБЕЭЗХ – ийн бүс нутгаас гадуурх улс орнуудыг татан оролцуулахыг уриалах, үүний төлөөх хялбаршуулсан журам зэргийг баталсан.

Зүйл 6 нь төрөл бүрийн хувилбарууд нээлттэй байх төслийн эрт үе шатанд олон нийт оролцох боломжоор хангасан боломжийн хугацаат хуваарь гаргах, мөн ямар нэг төсөл, төлөвлөгөө ба хөтөрбөрүүдийн хувьд олон нийтийн оролцооны үр дүнг “Хариуцлагын данс” хэлбэрээр хэрэглэх үүргийг хангуулах заалтуудтай холбогддог. Зүйл 7-д байгаль орчинтой холбоотой төлөвлөгөө, хөтөлбөрийг бэлдэх үед олон нийтийг оролцуулах зохих амьдралд нийцсэн болон бусад заалтуудыг шаарддаг.

Монгол улсын Засгийн газар нь уг конвенцид одоогоор гарын үсэг зураагүй боловч 2011 оны 7-р сар болсон Талуудын Уулзалтын үед НҮБЕЭЗХ-нд албан тоотоор дамжуулан нэгдэх сонирхолтой буйгаа илэрхийлсэн. Монголын хууль аль хэдийн Орхусын Конвенцитай зарчмын хувьд нийцэх боловч сонирхолоо илэрхийлсэн албан тоотоос үзвэл байгаль орчин, хүний эрхийн асуудлуудад олон нийтийн оролцоог хангуулах засгийн газрын цаашдын үүрэг амлалтыг илэрхийлнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаар нэвтэрч үзнэ үү: www.unece.org/env/pp/introduction.html.

3 Оролцогч талуудтай өмнө нь хийсэн уулзалтын үйл ажиллагааны дүгнэлт

Одоог хүртэл орон нутгийн хүмүүстэй гурван уулзалтыг зохион байгуулсан байна (Хүснэгт 3.1-ийг харна уу). Эдгээр уулзалтын гол зорилгууд нь:

- Төслийн талаар болон төслийн БОННБҮ-ний үйл явцыг танилцуулах
- Цахилгаан дамжуулах шугам, замууд, бусад талбай дээрх байгууламжуудыг хамруулсан Төслийн барилга угсралт, ашиглалттай холбоотой Төслийн болзошгүй нөлөөллүүд болон үр өгөөжийг хэлэлцэж, тогтоох.
- Төслийн талбай ба ойр орчмын газар ашиглалт, тэнд ажиллаж, амьдарч буй нутгийн иргэдийн үйл ажил, амьдралын хэв маягийг ойлгох
- Ирээдүйд мэдээллийг түгээх хамгийн үр дүнтэй замыг тогтоох
- Төслийн нөлөөлөлд өртөх магадлалтай оролцогч талуудын бүлгүүд ба нутгийн иргэдийн жагсаалтыг гаргах

Хүснэгт 3.1: БОННБҮ-ний хэлэлцүүлэх үйл ажиллагаа

Огноо	Оролцогчид	Байрлал	Хэлэлцүүлгийн гол сэдэв
2014.04.03	Ньюком ХХК-н төлөөлөгчид ба орон нутгийн төлөөлөгчид	Цогтцэций сум, Өмнөговь	Төслийн барилга угсралттай холбоотой танилцуулга, мэдээллээр хангасан. Байгаль орчинд ээлтэй технологи, зам ба дэд бүтцийг сайжруулах, орон нутгийн уурхайн компаниудыг оролцуулан орон нутгийг цахилгаанаар хангах зэрэг салхин станцын давуу талуудын талаар уг уулзалтын үеэр дэлгэрэнгүй ярилцсан.
2014.06.07	Клин Энержи Ази, Санни Трэйд ХХК, Цогтцэций сумын Сийрст баг.	Цогтцэций сум, Өмнөговь	Байгаль орчны үнэлгээтэй холбоотой мэдээллээр хангах, ажлын гүйцэтгэлүүдийн талаар дэлгэрэнгүй илтгэл тавьсан. СЦҮ-үүдийг ашиглан салхины эрчим хүчнээс хэрхэн цахилгааныг үйлдвэрлэх, энэ Төсөл нь хэрхэн Монголын хоёр дахь салхин станцын төсөл болох тухай мэдээллээр хангасан. Байгаль орчны асуудлууд, нөхөн сэргээх арга хэмжээг мөн хэлэлцсэн.
2014.09	18 малчид.	Салхит СЦС.	Нутгийн иргэд ажиллаж буй Салхит СЦС-тай очиж танилцсан.
2014.10.01	Клин Энержи Ази, Сгурр Энержи ХХК, Цогтцэций сумын Сийрст багийн төлөөлөгчид. Нутгийн малчид.	Цогтцэций сум, Сийрст багийн засаг даргын тамгын газар.	КЭА нь Төсөл ба Сгурр Энержи-г танилцуулсан. Сгурр Энержи нь БОННБҮ-н үүргийг танилцуулж, дуу шуугиан, харагдах байдал, эдийн засаг зэрэг асуудлуудыг онцгойлж, эдгээр нь нутгийн иргэдэд асуудал болох эсэхийг лавлаж асуусан. Сгурр Энержи нь нөлөөллийг хамгийн бага хэмжээнд байлгах аар салхин станцыг загварчлах болохыг тайлбарласан. КЭА нь Төсөлтэй холбоотойгоор орон нутагт гарах үр өгөөжийн талаарх мэдээллийг өгсөн.

Эх сурвалж: Сгурр Энержи (2015)

Уулзалтын үеэр оролцуулагч талуудаас тавьсан салхин парк ямар харагдах, орон нутгийн ажил эрхлэлт, боловсрол зэрэг орон нутгийн иргэдэд ямар үр өгөөжтэй болох, Цэций ууланд ямар нөлөө үзүүлэх зэрэг асуултуудад хариулсан. КЭА-ийн зүгээс санал болгох орон нутагт оруулах хувь нэмэр, жишээлбэл зарим нэг хязгаарлагдмал ажлын байрыг орон нутагт бий болгох, нутгийн оюутнуудын боловсролыг дэмжих талаарх мэдээллийг өгсөн. Сгурр Энержи Цогтцэций сумаас салхин парк хэрхэн харагдахыг үзүүлсэн Төслийн утсан хүрээт харагдац зургийн² хуулбаруудыг тарааж өгсөн. Мөн Сгурр Энержигээс төслийн нөлөөллийг хамгийн бага хэмжээнд байлгах аар зураг төсөл хийхийг харин КЭА-аас уулын орчимд СТГ-уудыг угсрахгүй болохыг баталж хэлсэн.

² Утсан хүрээт загвар бол гурван хэмжээсээр (3D) үзүүлэх танилцуулга буюу 3D компьютер графикт ашигладаг биет зүйл юм.

4 Оролцогч талуудыг тогтоох ба харилцах аргууд

Төслийн оролцогч талуудын талаар хийсэн дүн шинжилгээг доорх Хүснэгт 4.1-д үзүүлэв. Ялгаатай оролцогч талуудын бүлгүүд болон сонсогчидтой харилцах ажлыг байрлал, хэл, хэвлэл мэдээлэл, ил болгох материалуудын хувьд ялгаатай байх бөгөөд тэдний зохих түвшинд нь тааруулан гүйцэтгэнэ. Төслийн нөлөөлөлд өртөх хамгийн эмзэг бүлгүүдэд Төслийн талбайд улирлын чанартай амьдрах, гол уулзалтуудын талаар мэдээлэл хүргэгдэхгүй эсвэл оролцож чадахгүй байж болох, түүнчлэн мэдээлэлд авах хязгаарлагдмал боломжтой нүүдлийн малчид орно.

Уг ОТУТ болон доорх хүснэгтийг Төслийн бүх шатны турш шинэ оролцогч талуудыг тогтооход байнгын давтамжтай шинэчилж байна.

Хүснэгт 4.1: Оролцогч талуудын тодорхойлолт ба харилцаа

Оролцогч талууд	Харилцааны тухай	Харилцах хэлбэр	Үүрэг	Хугацаа	
Дотоод оролцогчид					
КЭА-ийн ажиллах хүч	КЭА талбай дээрх харилцааг явуулна.	<ul style="list-style-type: none"> КЭА дээрх амралтын өрөө эсвэл корридор тавьсан мэдээллийн самбар (харагдах байрлалыг тогтоох) Цалингийн хуудаст хавсаргасан мэдээлэл Ажилчдын гомдол шийдэх үйл явц 	<ul style="list-style-type: none"> Хүний нөөцийн менежер эсвэл Талбайн менежер 	<ul style="list-style-type: none"> Сар бүр Улирал бүр Гомдол шийдвэрлэх бүрт 	
Барилгын ажилчид, давхар гэрээлэгчид (барилга угсралтын үед ажиллах хэдэн зуун ажилчид)	КЭА талбай дээрх харилцааг явуулна.	<ul style="list-style-type: none"> Гэрээний мэдээлэл КЭА-ийн оффис дээрх мэдээллийн самбар (олон улсын ажиллагсадад зориулан олон хэл дээр байх – Монгол, Хятад ба бусад тогтоосон хэлүүд) Сургалт ба ээлж солигдохын эхэнд явуулах тусгай яриа Ажилчдын гомдол шийдэх явц 	<ul style="list-style-type: none"> Хүний нөөцийн менежер эсвэл Талбайн менежер 	<ul style="list-style-type: none"> Барилгын ажлын өмнө Барилгын шатанд сард багадаа нэг удаа Барилгын шатанд сард багадаа нэг удаа Барилгын шатанд сард багадаа нэг удаа Гомдол шийдвэрлэх бүрт 	
Гадны оролцогч талууд					
Цогтцэций сум болон Сийрст багын оршин суугчид	<ul style="list-style-type: none"> Сумын төвийн оршин суугчид (6100 орчим хүн) Багийн оршин суугчид (1300 орчим хүн) Талбайн ба түүний орчимд малаа бэлчээж, гэр барин улирлын чанартай оршин суудаг малчид өрхүүд 	<ul style="list-style-type: none"> Сумын засаг дарга Багийн засаг дарга Бэлчээр ашиглах бүлэг буюу бусад малчдын төлөөлөгчид Бие даасан малчид 	<ul style="list-style-type: none"> Талбай дээрх нийтийн мэдээллийн самбар ба Цогтцэций сумын төвийн мэдээллийн самбаруудаар мэдээлэх БОННБУ-ний төслийг нийтлэх, барилгын шатны ашиглалтнаас гаргах хүртэл Төслийн гол шатуудад сумын төв дээр олон нийтээр хэлэлцүүлэх уулзалт Сумын болон багийн тамгын газраар дамжуулан танилцуулга материал тараах Дараах хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр гаргах: 	<ul style="list-style-type: none"> Олон нийттэй харилцах мэргэжилтэн Олон нийттэй харилцах мэргэжилтэн Олон нийттэй харилцах мэргэжилтэн Олон нийттэй харилцах мэргэжилтэн /Хүний нөөцийн менежер / Талбайн менежер 	<ul style="list-style-type: none"> Барилгын ажил эхлэхээс өмнө сардаа нэг удаа шинэчлэх Барилгын ажил эхлэхээс өмнө ба Төслийн насжилтийн турш дахь гол шатуудад БОННБУ- төслийг ил болгох явцад, барилгын ажил эхлэхээс өмнө, Төслийн насжилтийн турш жилдээ нэг удаа Төслийн шинэчлэл хийхийг шаардахад, ажлын байрны заруудад

Оролцогч талууд	Харилцааны тухай	Харилцах хэлбэр	Үүрэг	Хугацаа	
		<ul style="list-style-type: none"> Цэций инфо” (Цэций сумын засаг даргын тамгын газраас гаргадаг орон нутгийн сонин), “Өдрийн сонин”, “Өнөөдөр” “Алтан нутгийн мэдээ” Улаанбаатарт суугаа нутгийн иргэдийн бэлтгэн гаргаж, хэвлүүлдэг сонин 			
		<ul style="list-style-type: none"> “DDISH TV”, “Орчлон”, “Малчин” зэрэг телевизүүд Цахим хуудсууд (хязгаарлагдмал хэрэглээ) 	<ul style="list-style-type: none"> Олон нийттэй харилцах мэргэжилтэн / Талбайн менежер 	<ul style="list-style-type: none"> Шаардлагатай үед 	
		<ul style="list-style-type: none"> Имэйл (хязгаарлагдмал хэрэглээ) 	<ul style="list-style-type: none"> Олон нийттэй харилцах мэргэжилтэн 	<ul style="list-style-type: none"> Шаардлагатай үед 	
Хамгийн ойрын суурин	Цогтцэций (2013 онд барагцаагаар 6108 оршин суугч)	Цогтцэций сумын засаг дарга	<ul style="list-style-type: none"> Холбогдох төслийн шагуудын олон нийтээр хэлэлцүүлэх хурал 	<ul style="list-style-type: none"> Олон нийттэй харилцах мэргэжилтэн 	<ul style="list-style-type: none"> Барилгын ажлын өмнө Ашиглалтад оруулахын өмнө Ашиглалтнаас гаргахын өмнө
			<ul style="list-style-type: none"> Сонинд гаргах 	<ul style="list-style-type: none"> Барилгын ажлын өмнө 	
			<ul style="list-style-type: none"> Барилгын талбай дээрх нийтийн мэдээллийн самбар 	<ul style="list-style-type: none"> Барилгын ажлын 	
Малчид ба бусад газар ашиглагчид	Төслийн талбайг дайрч өнгөрөх боловч суурин биш малчид	Бэлчээрийн ашиглагч бүлэг эсвэл төсөөтэй малчдын төлөөлөгчидөөр дамжуулан	<ul style="list-style-type: none"> Олон нийтээр хэлэлцүүлэх уулзалт 	<ul style="list-style-type: none"> Олон нийттэй харилцах мэргэжилтэн 	<ul style="list-style-type: none"> БОННБҮ-ний төслийн ил болгох явцад Гомдол барагдуулах явцад
			<ul style="list-style-type: none"> Гомдол барагдуулах механизм 	<ul style="list-style-type: none"> Олон нийттэй харилцах мэргэжилтэн 	<ul style="list-style-type: none"> Гомдол бүрийг барагдуулах явцад
			<ul style="list-style-type: none"> Төслийн мэдээллийн хуудас 	<ul style="list-style-type: none"> Олон нийттэй харилцах мэргэжилтэн 	<ul style="list-style-type: none"> БОННБҮ-ний төслийн ил болгох явцад
Аймгийн засаг захиргаа	<ul style="list-style-type: none"> Усны хэлтэс Биет байдлын төлөвлөлтийн хэлтэс Хотын асуудал эрхэлсэн хэлтэс 	Хэлтсийн дарга нар	<ul style="list-style-type: none"> Хэлтсийн дарга нартай имэйлээр харилцах. 	<ul style="list-style-type: none"> Олон нийттэй харилцах мэргэжилтэн 	<ul style="list-style-type: none"> Барилгын ажлын өмнө Шаардлагатай үед

Оролцогч талууд	Харилцааны тухай	Харилцах хэлбэр	Үүрэг	Хугацаа	
	<ul style="list-style-type: none"> Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ (ЦДҮС) Диспетчерийн үндэсний төл (ДҮТ) 	<ul style="list-style-type: none"> Албан ба албан бус уулзалтууд /шаардлагатай үед 		<ul style="list-style-type: none"> Шаардлагатай үед 	
Монголын засгийн газар	<ul style="list-style-type: none"> Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам Сангийн яам 	Албан ёсны холбоо барих хаягийн дагуу имэйлээр харилцах	<ul style="list-style-type: none"> Төсөлд шаардлагатай зөвшөөрөл авах албан, албан бус харилцаа Шаардлагатай үед албан ба чөлөөт уулзалт хийх 	<ul style="list-style-type: none"> Олон нийттэй харилцах мэргэжилтэн Олон нийттэй харилцах мэргэжилтэн 	<ul style="list-style-type: none"> Шаардлагатай үед Шаардлагатай үед
ТББ-ууд	<ul style="list-style-type: none"> Монгол улсын салхины эрчим хүчний нийгэмлэг Монголын Хүний Эрх, Хөгжлийн төв Говь хөрс, Хан богд сум, Монгол Оюу толгойн Хяналт, Монгол Цэций нутаг / Цэций сум Хил хязгааргүй алхам 	<ul style="list-style-type: none"> e.myagmardorj@gmail.com Г. Уранцоож, gurantsooj@rocketmail.com Л. Батцэнгэл, tsengel_5595@yahoo.com Д. Сүхгэрэл, otwatch@gmail.com Холбогдох хаягийн тодруулах Н. Баярсайхан (ОТ Хяналт) 	<ul style="list-style-type: none"> ТБХД-ийг имэйлээр явуулах Барилгыг эхлүүлэхийн өмнө болон чухал шатуудад имэйлээр мэдэгдэл хүргүүлэх Жилийн тайлан/ цахим хуудсаар нийтлэн ил болшоо (цахим хуудсыг дараагийн шатанд тодорхой болгоно) Төслийн холбогдох шатуудад хийх олон нийтийн хэлэлцүүлэг уулзалт 	<ul style="list-style-type: none"> Олон нийттэй харилцах мэргэжилтэн Олон нийттэй харилцах мэргэжилтэн Олон нийттэй харилцах мэргэжилтэн Олон нийттэй харилцах мэргэжилтэн 	<ul style="list-style-type: none"> Барилгын ажил эхлэхээс өмнө Барилгын ажил эхлэхээс өмнө, барилгын гол шатуудад Жил бүр Барилгын ажлыг эхлэхээс өмнө, ашиглалтанд оруулахаас өмнө
Жижиг бизнес эрхлэгчид	<ul style="list-style-type: none"> КЭА-ийг хангах боломжтой Өмнөговь аймгийн нийлүүлэгчид Цогтцэций сумын төвийн дэлгүүр, үйлчилгээ 	2 сумын төв	<ul style="list-style-type: none"> Олон нийтээр хэлэлцүүлэх уулзалт Барилгын шатны гол үеүдэд имэйлээр мэдэгдэх (хүсэлт гаргасан бол) 	<ul style="list-style-type: none"> Олон нийттэй харилцах мэргэжилтэн 	<ul style="list-style-type: none"> Барилгын ажил эхлэхээс өмнө ба ажлын үед Ашиглалтын шатанд жил бүр Шаардлагатай үед
Бусад сонирхсон	Олон улсын ТББ-ууд, сонирхсон талууд, оюутнууд		<ul style="list-style-type: none"> Бүртгэлтэй бол имэйлээр мэдэгдэх 	<ul style="list-style-type: none"> Олон нийттэй харилцах мэргэжилтэн 	<ul style="list-style-type: none"> Шаардлагатай үед

Оролцогч талууд	Харилцааны тухай	Харилцах хэлбэр	Үүрэг	Хугацаа
талууд	ба аливаа бусад талууд	<ul style="list-style-type: none"> Цахим хуудсанд суурилсан харилцаа 	<ul style="list-style-type: none"> Олон нийттэй харилцах мэргэжилтэн 	<ul style="list-style-type: none"> Шаардлагатай үед
		<ul style="list-style-type: none"> Олон нийтээр хэлэлцүүлэх уулзалтууд 	<ul style="list-style-type: none"> Олон нийттэй харилцах мэргэжилтэн 	<ul style="list-style-type: none"> Шаардлагатай үед
		<ul style="list-style-type: none"> Сонингийн зарлал 	<ul style="list-style-type: none"> Олон нийттэй харилцах мэргэжилтэн 	<ul style="list-style-type: none"> Шаардлагатай үед

5 Хэлэлцүүлэх ба ил болгох хөтөлбөр

Төслийн хувьд онцлох олон нийттэй харилцах шатууд дараах байдлаар ангилагдаж болно:

- Төсөл хөгжүүлэлтийн шатанд КЭА-ийн зохион байгуулах хэлэлцүүлгүүд:
 - Төслийн байгаль орчны зөвшөөрлийг авахын өмнө орон нутгийн оролцогч талууд ба зөвшөөрөл өгөх газруудаар БОННБҮ-ийг хэлэлцүүлэх,
 - Дамжуулах шугам баригдах чиглэлийн төрийн өмчит газрын зөвшөөрөл, түүний барилга ба засвар үйлчилгээг хийх эрхийн талаар хэлэлцүүлэгүүд.
- БОННБҮ-ний явцын нэг хэсэг болох хэлэлцүүлэг ба уулзалтууд. БОННБҮ холбоотой хэлэлцүүлэх уулзалтуудын нэг шатыг хийж дуусгасан болно. Энэ тухай болон цаашид төлөвлөсөн үйл ажиллагааны талаар мэдээллийг Хүснэгт 5.1-аас харна уу:
 - Төслийн танилцуулга;
 - БОННБҮ-ний хэлэлцүүлэг;
 - Нийтлэн ил болгох.

Удаах хэсэг болон Хүснэгт 5.1-д Төслийн бүхий л үе шатуудад КЭА болон түүний Инженерчлэл, Худалдан Авалт, Барилга Угсралтын гэрээлэгчдийн явуулах төлөвлөсөн уулзалтын хөтөлбөрийг тоймлон дүгнэв.

5.1 Нөөц боломж ба үүрэг хариуцлага

Оролцогч талуудын харилцаа нь Төслийн стратеги төлөвлөлт, удирдлага, өдөр тутмын үйл ажиллагааны чухал элемент юм. КЭА нь төлөвлөлт ба барилга угсралтаас эхлээд ашиглалтнаас гарган хаах хүртэлх Төслийн бүхий л үе шатын турш энэ үйл явцад зохих нөөц боломжоор хөрөнгө оруулалт хийнэ.

Оролцогч талуудын харилцаан дахь гол үүрэг ба хариуцлагуудыг одоогийн байдлаар зааж өгөөгүй боловч уг ОТУТ-ийг хэрэгжүүлэх Олон нийттэй Харилцах Мэргэжилтэн (ОНХМ)-ийг томилж өгнө. ОНХМ нь нутгийн иргэд болон бусад оролцогч талуудын талаар мэдээллийг шинэчлэн цуглуулах, мөн аливаа асуудлыг урьдчилан тооцоолж, тайлагнаж байх үүрэгтэй. ОНХМ нь малчидтай газар дээр нь орчиж уулзах зэрэг нутгийн иргэдтэй тогтмол уулзалтыг явуулж байна. Мөн ОНХМ нь Талбайн эсвэл Төслийн Менежерт ажлаа тайлагнаж байна.

Түүнчлэн ОНХМ нь ОНУТ-ний хэрэгжилт, гомдлын дүн шинжилгээг КЭА-ийн удирдлага болон бусад гадны оролцогч талуудад цаг бүрт нь тайлагнах үүрэгтэй. ОТУТ-ийг жил бүр хянан шүүж, хэрэгцээтэй бол шинэчилнэ.

Хүснэгт 5.1: БОННБҮ-г нийтлэн ил болгох, хэлэлцүүлэх

Нийтлэх мэдээлэл / хэлэлцэх асуудлууд	Хугацаат хуваарь	Харилцаа / хэвлэл мэдээллийн хэрэгсэл	Байрлал	Оролцогч талууд үгээ хэлэх боломж
Ерөний танилцуулга				
Төслийн тодорхойлолт, анхны үзэл бодлыг сонсох	БОННБҮ-ийг танилцуулах – хийж дууссан	Орон нутгийн зөвлөлийн гишүүд, Цогтцэций сум болон Сийрст багийн малчдын төлөөлөгчидтэй хийсэн уулзалт	Цогтцэций сум, Өмнөговь Цогтцэций сум, Сийрст багийн тамгын газар	Уулзалтын үед
Нийтлэн ил болгох				
БОННБҮ-ний багц: БОННБҮ, БОННБҮ, Техникийн Бус Дүгнэлт (ТБД), энэхүү ОТУТ, Байгаль орчин, нийгмийн арга хэмжээний төлөвлөгөө(БОНАХТ)	2016 оны 3-р сараас 5-р сарын турш олон нийтийн хянан шүүх хугацаа	БОННБҮ-ний багцийг олон нийт хянаж шүүх, санал асуулга тавих боломжтой болохыг мэдэгдсэн сурталчилгаа, зарлалууд орон нутгийн болон үндэсний сонин хэвлэл дээр нийтлэх (Өнөөдөр, Өдрийн сонин), мөн Төслийн толгой компаниудын цахим хуудас (www.newcom.mn and www.sbenergy.co.jp) in Англи ба Монгол хэлээр, ЕСБХБ-ний цахим хуудсанд Англи хэлээр. Хүсэлтийн дагуу имэйлээр явуулах	Цахим хэлбэрээр (дараагийн шатанд тодорхой болох цахим хуудас дээр) Хяналт шүүмжид зориулсан цаасан хэлбэрээр: <ul style="list-style-type: none"> • Сумын засаг даргын тамгын газар • КЭА-ийн оффисууд • Зээлдүүлэгчийн цахим хуудас 	Эцсийн хувилбараар батлахаас өмнө оролцогч талууд аливаа санал хүсэлтээ энэхүү тайлангийн Хэсэг 7-д заасан хаягаар бүртгүүлэх боломжтой.
БОННБҮ-ний хэлэлцүүлэг				
БОННБҮ-ний олон нийтээр хэлэлцүүлэх үйл явдлын мэдэгдэл	Эхний хэлэлцүүлэг болохоос багадаа 30 хоногийн өмнө	Цогтцэций сумын бодит байрлалуудад нийтийн мэдэгдэл гаргах, сонинд гаргах (Өнөөдөр, Өдрийн сонин) ба Төслийн толгой компаний цахим хуудсууд (www.newcom.mn and www.sbenergy.co.jp) -дад Англи ба Монгол хэлээр нийтлэх	Зохих үндэсний болон орон нутгийн сонин хэвлэлд гаргасан нийтийн зар мэдэгдэл Олон нийтийн газруудад мэдэгдэл байрлуулах	Хэлэлцүүлгийн үед оролцогч талуудын санал хүсэлтийн маягтаар дамжуулан авах.
БОННБҮ-ний үр дүн, БОНМТ	Дээрх мэдэгдлийг хэвлүүлснээс дор хаяж 30 хоногийн дараа	БОННБҮ-ий багийн гишүүд, КЭА-ийн ажилчидтай хамт олон нийтийн хэлэлцүүлгийг Англи болон Монгол хэл дээр явуулах. Төсөл, БОННБҮ-ийн ажил болон гол үр дүнг Англи болон Монгол хэлээр ТБД-ийг ашиглан тайлбарлах. Бүс нутгийн засаг захиргааны удирдлагууд, ТББ-ууд энэ үйл явдалд уригдсан байна.	Цогтцэций сумын оршин суугчид ба малчдад хялбар хүрэх сумын олон нийтийн газар.	Тухайн хэлэлцүүлгийн үед. Олон нийтийн гомдол барагдуулах журмаар.
БОННБҮ-ийн үр дүн, БОНМТ	БОННБҮ багцыг нийтлэн ил болгосноос багадаа 30 хоногийн дараа	Холбогдох засаг захиргааны хэлтсүүд зэрэг дээд шатны удирдлагуудтай уулзах	КЭА оффис эсвэл Цогтцэцийн ба/Улаанбаатарын төрийн байгууллага г.м уулзах талын зохимжтой гэж үзсэн газар	Уулзалтын үеэр.

Хүснэгт 5.2: Барилга угсралт ба ашиглалтын шатны турш КЭА болон түүний ИХАБУ-н гэрээлэгчдийн явуулах уулзалтын үйл ажиллагаа

Нийтлэх мэдээлэл / хэлэлцэх асуудлууд	Хугацаат хуваарь	Харилцаа / хэвлэл мэдээллийн хэрэгсэл	Байрлал	Оролцогч талууд үгээ хэлэх боломж
Олон нийтийн гомдол барагдуулах механизм (Хэсэг Error! Reference source not found. -ийг харна уу).	БОННБУ-г бэлтгэхийн зэрэгцээ	<ul style="list-style-type: none"> Цахим хуудас: (currently www.newcom.mn ба www.sbenergy.co.jp) Уг ОТУТ-ний Хэсэг Error! Reference source not found.-д заасан холбогдох хаяг Гомдол барагдуулах механизмд чиглэсэн олон нийтийн уулзалт 	Сумын засаг даргын тамгын газар ба бусад байрлалуудыг тогтоох	Нэгэнт гомдол барагдуулах механизмыг ашиглаад эхэлвэл олон нийт Төслийн бүхий л шатан дахь гомдол хүсэлтээ мэдүүлж болно.
Төслийн хуваарь	үүнээс нэг сарын өмнө: <ul style="list-style-type: none"> Барилгын ажил эхлэх Бусад үндсэн ажлууд Аливаа ноцтой асуудлууд байвал дахин хийх 	<ul style="list-style-type: none"> Төслийн барилгын талбайн орох хаалга болон сумын засаг даргын тамгын газар дээр байрлуулах Хүсэлт ирүүлсэн талд имэйлээр явуулах Цахим хуудас: (дараагийн шатанд цахим хуудсыг тодорхойлох) 	<ul style="list-style-type: none"> Төслийн барилгын талбайн орох хаалга болон талбайтай ойр чухал газрууд Сүм хийд, сургууль, хотын захиргаа, номын сан, цагдаагийн хэлтэс зэрэг олон нийтийн барилгууд. 	Барилгын үе шат болон боломжтой бол нийтийн гомдлыг барагдуулах явцад дамжуулан хэрэгжүүлэх шатууд.
Төслийн байнгын шинэчлэл	Барилгын шатанд сар бүр, бусад үед сард хоёр удаа	<ul style="list-style-type: none"> Танилцуулах хуудас³ болон уулзалтын мэдэгдэл Хүсэлтийн дагуу сонирхсон талд имэйлээр явуулах Цахим хуудас: (одоогоор www.newcom.mn ба www.sbenergy.co.jp) 	Тодорхойлох	Уулзалтын үед Олон нийтийн гомдол барагдуулах механизм
Нээлттэй өдөрлөг	Ашиглалтын үед жил бүр	Төслийн талбай ба байгууламжийг олон нийтийн сонирхсон гишүүдэд хөтөчлөн үзүүлэх	Төслийн талбай	Нээлттэй өдөрлөгийн үеэр
Ажиллагсадын гомдлыг барагдуулах механизм	Барилгын болон ашиглалтын үе шатуудад	Амралтын өрөөний зарлалын самбар, Төсөлд ажилчдын шинэ бүлэг ажлаа эхлүүлэх үед хийх яриа	Төслийн барилга угсралтын шат	Ажиллагсад (гэрээний ажилчдыг хамруулан) ажиллагсадын гомдол барагдуулах механизмаар дамжуулан хэзээд ч гомдлоо мэдүүлж болно.
Хөдөлмөрийн хугацаа ба нөхцөл		Гэрээнд багтаасан.	Хамааралгүй	Ажиллагсадын гомдол барагдуулах механизмаар дамжуулан
Хүний нөөц ба Байгаль орчин, Эрүүл мэнд ба Аюулгүй ажиллагааны (БОЭМАА) бодлого, журам		Гэрээнд багтаасан.	Хамааралгүй	ажиллагсадын гомдол барагдуулах механизмаар дамжуулан

³ Төслийн хамгийн чухал сүүлийн үеийн мэдээ, байгаль орчин, нийгмийн хяналт шинжилгээний мэдээлэл, гомдол шийдвэрлэсэн байдал, барилгын ба ажлын байрны мэдээ хамруулсан.

6 Гомдол барагдуулах механизм

Олон нийтийн санал гомдлыг шийдвэрлэх нь КЭА-ийн удирдлагын ахлах ажилтнуудын чухал үүрэг боловч үүнийг ОНХМ удирдан, зохион байгуулна. КЭА ба Гэрээлэгчид Төсөлтэй холбоотой бүхий л санал хүсэлт, гомдлыг хүлээн авч, харгалзан үзнэ. Аливаа хүн эсвэл байгууллага нь өөрийн биеэр, утсаар, шуудан эсвэл имэйлээр энэхүү бичиг баримтны сүүлийн хэсэгт оруулсан холбогдох мэдээллийн дагуу санал хүсэлт эсвэл гомдорр ирүүлж болно.

Санал гомдол гаргагч этгээдийн холбогдох хаяг өгөгдсөн тохиолдолд бүхий л санал хүсэлт, гомдлыг нь Санал гомдол барагдуулах маягтад бичин авч, санал гомдол гаргагчийн заасны дагуу бичгээр эсвэл амаар хариу өгнө.

Санал гомдлын талаарх мэдээллийг ОНХМ нь гомдлын протоколд тэмдэглэж байна. Үүнд дараах үндсэн мэдээлэл орно:

- Оролцогч талуудын нэр ба холбогдох мэдээлэл
- Санал гомдлын мөн чанарын талаар дэлгэрэнгүй мэдээлэл
- Хүлээн авсан, хариу хүргүүлсэн огноо
- Хааж шийдвэрлэсэн өдөр,
- Хэрхэн бүртгэгдсэн, судлагдсан, хариулагдсан ба хаагдсан эсэх

Хувь хүн нэрээ өгөхгүй байх эсвэл нууцлахыг хүсэж болно. Гэсэн хэдий ч КЭА нь нэр мэдэгдэхгүй этгээдийн санал гомдолд хариу өгөхөөр шууд харилцаж чадахгүй.

Санал гомдлын протоколын үндсэн үүрэг нь гомдлын ноцтой байдал, хуулийн үндэслэлд суурилан юуны түрүүн арга хэмжээ авах болно. **Error! Reference source not found.**-д гомдлын ердийн зэрэглэлийг үзүүлсэн а “зэрэглэл 1”-д хамгийн яаралтай, “зэрэглэл 3”-д яаралтай биш асуудлууд хамаарна. Төслийн насжилтын турш уг зэрэглэлийг шинэчлэж, сайжруулна.

Хүснэгт 6.1: Гомдлын зэрэглэл

Гомдлын зэрэглэл	Тайлбар	Хариулах хугацаа	Хариулах хэлбэр
1	Амьдрах газар (газар чөлөөлөх асуудлуудыг хамруулан), эрүүл мэнд ба аюулгүй байдал, хувийн ба нийтийн хөрөнгө, эсвэл аливаа хүний эрхэд нөлөөлж буй Төсөлтэй холбоотой гомдлууд. Мөн эмзэг хувь хүн болон бүлэгт ⁴ нөлөөлж байна гэж үзвэл санал гомдлыг “1”-д хамруулна. 50-аас дээш хүний тав тух, амар амгаланд нөлөөлвөл “1” гэж үзнэ.	Санал гомдлыг нэг долоо хоногийн дотор шийдэх эсвэл яагаад үүнээс илүү хугацаа орох тухай тайлбар өгөх.	Үзлэг шалгалтын багийг үзлэг хийх, шийдэхэд зориулан томилох. Ажлыг нөлөөлөгдсөн газарт нь зогсоож болно. ОНХМ нь гомдлыг хүлээн авсан даруй судалж илгээнэ.
2	Төслийн үйл ажиллагаанаас болж цөөн тооны хүмүүсийн тав тух, амар тайван байдалтай холбоотой бол гомдлыг ‘зэрэглэл 2-р ангилна’.	Санал гомдлыг гурван долоо хоногт багтаан шийдэх эсвэл яагаад үүнээс илүү удах талаар тайлбар гаргах.	ОНХМ болон зохин үзлэгийн баг үзлэг шалгалтыг хийнэ. Талбайн менежер эсвэл Эрүүл мэнд, Аюулгүй Ажиллагааны менежер үзлэгийн үед уг ажлыг зогсоож, засаж залруулах арга хэмжээг олж тогтоох эсэхийг шийднэ. ОНХМ нь гомдлыг хүлээж авснаас долоо хоногийн дотор асуудлыг судалж, илгээнэ.
3	Сайжруулах санал, эсвэл гомдлын бусад төрөл нь ‘зэрэглэл 3’ болно.	Зургаагаас найман долоо хоногийн дотор саналыг	ОНХМ нь саналыг компани дотроо хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулна.

⁴ The DEIA identifies the most vulnerable group to the project as nomadic herders who seasonally inhabit the area and who may not attend key meetings and have limited access to information.

Гомдлын зэрэглэл	Тайлбар	Хариулах хугацаа	Хариулах хэлбэр
		харгалзан үзнэ.	ОНХМ нь санал ирүүлсэн этгээдэд хүлээн авч судалсан хариуг өгч, түүний дараагаар авсан чухал арга хэмжээнүүдийг тоймлосон хариу хүргүүлнэ.

Олон нийтийн гишүүдээс гомдол хүсэлт цуглуулахын тулд хэд хэдэн тооны зохих байрлалуудад зориулалтын гомдол хүсэлтийн хайрцгуудыг байршуулна. Санал болгож буй гомдлын хайрцгуудад дараах багтана:

- Цэций дэх сумын засаг даргын тамгын газар дотор нэг санал хүсэлтийн хайрцаг
- КЭА-ийн төв хаалга
- Цогтцэций сумын төвд малчдад тохиромжтой нэг байршил
- Төлөвлөж буй ЦДАШ-ийн чиглэлийн дагуу гурван байршилд

Санал хүсэлтийн хайрцгууд нь цоожтой, цаг агаарт тэсвэртэй байх бөгөөд эхний үед долоо хоногт нэг удаа, түүний дараа хэрэгцээний түвшингөөс шалтгаалан хоёр долоо хоногт нэг удаа шалгана. Хайрцгуудыг шалгах үүргийг ОНМХ биелүүлнэ. Санал хүсэлтийн маягтаар тасралтгүй хангахын тулд маягтыг орон нутгаар өргөн хэмжээнд тараана. Хавсралт А-д стандарт санал хүсэлтийн маягтыг үзүүлэв.

Утас, имэйл, захиагаар болон уулзалтын үед биеэр өгсөн зэрэг бусад сувгаар бүртгүүлсэн санал гомдлыг мөн хүлээн авах ба нэгэн ижил гомдол барагдуулах механизмаар дамжуулан шийднэ.

Уг механизм нь гомдлыг гомдол гаргагчийн хууль зүйн эрхийн байрнаас авч үздэггүйг дурдах нь зүйтэй. Хүн гомдлоо бүтгүүлсэн ч гэсэн өөрийн асуудлыг шийдэх бусад хууль зүйн арга хэрэгслийг хэрэглэх боломжтой.

КЭА нь Гэрээлэгчид санал гомдлыг шийдэж буй арга замыг хянан шинжилж, дээрх өгөгдсөн хугацааны дотор зүй ёсоор санал гомдлыг шийдвэрлүүлнэ.

КЭА-ийн ажиллагсдад зориулсан тусдаа, дотоод гомдол барагдуулах механизм байх бөгөөд гэрээний ажилчдын хувьд ажиллаж эхэлмэгц түүнийг ашиглах боломжтой болно.

7 Компанитай холбогдох мэдээлэл

Уг ОТУТ-ийг бэлдэх энэ цаг мөчид ОНХМ-ийг хараахан томилоогүй байна. КЭА нь БОНБНҮ, БОННБҮ, Байгаль орчин, нийгмийн арга хэмжээний төлөвлөгөө болон уг ОТУТ-ийг нийтлэн ил болгохоос өмнө эсвэл тухайн үед оролцогч талуудын харилцаа ба санал гомдлыг зохион байгуулах ОНХМ-ийг томилох үүрэгтэй.

Төслийн Компанитай холбогдох мэдээллийг урьдчилсан байдлаар энд оруулсан бөгөөд ОНХМ-ийг томилсон даруй дахин шинэчилнэ.

Компаниас холбогдох хүн: М. Ариунболд

Орон нутгийн хаяг: Төслийн талбайг байгуулсны дараа тодорхойлох

Утасны дугаар: +976 11 345 252

Улаанбаатарын хаяг: “Найман зовхис” барилга, 10-р давхар
21 Сөүлийн гудамж
Улаанбаатар 14251
Монголиа

Утасны дугаар: +976 313183 (46)

Имэйл хаяг: Ariunbold@newcom.mn

Хавсралт А: Олон нийтэд зориулсан санал гомдлын маягт

<i>Хэрвээ та нэрээ мэдэгдэхийг хүсэхгүй бол дараах эхний гурван мөрийг бөглөхгүй үлдээнэ үү.</i>	
Овог нэр	
Холбоо барих мэдээлэл <i>Тантай хэрхэн холбоо барихыг хэлнэ үү (ө.х. шуудан, утас эсвэл и-мэйл). Нэрээ мэдэгдэхийг хүсэхгүй бол бөглөхгүй орхино уу.</i>	Шуудангийн хаяг: Утасны дугаар: И-мэйл хаяг:
Илүүд үзэх хэл (хайрцагийг зөвлөнө үү)	Монгол <input type="checkbox"/> Орос <input type="checkbox"/> Хятад <input type="checkbox"/> 7.1.1 Англи <input type="checkbox"/> Бусад <input type="checkbox"/>
<i>Хэрвээ та нэрээ мэдэгдэхийг хүсэхгүй бол дараах мөрнөөс эхэлнэ үү.</i>	
Эргэх холбоо буюу гомдлыг тайлбарлана уу (Юу болсон? Хаана болсон? Хэнд тохиолдсон? Асуудлын үр дагавар юу болох?):	
Хэрэг / гомдлын огноо	
Нэг удаагийн хэрэг /санал гомдлын огноо.....	
Нэгээс олон удаа тохиолдсон уу? Хэдэн удаа?	
Үргэлжилсээр байгаа (ө.х. одоо асуудалтай тулгарч байгаа) Тийм / Үгүй (дугуйлна уу)	
Асуудлуудыг хэрхэн шийдвэрлүүлэх хүсэлтэй байна вэ?	
Гарын үсэг.....Огноо.....	
Маягтыг дараахи газарт хүргүүлнэ үү: КЭА Цэцийн салхин парк эсвэл доор дурьдсан санал гомдлын хайрцагийн аль нэгт.	
Санал гомдлын хайрцагийн байршил: [тодорхойлох]	
(Зөвхөн албаны хэрэгцээнд) Санал гомдлын дугаар:	